



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	8
2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	8
2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал	11
3.1 Зардалтай холбоотой асуудал.....	11
3.2 Зардалтай холбоотой асуудал.....	11
3.3 Гэрээ ажил үйлчилгээтэй холбоотой асуудал.....	12
3.4 Зардалтай холбоотой асуудал.....	12
3.5 Төсвийн шууд захирагчдад илэрсэн алдаа зөрчлийн талаар	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5. Хавсралт	20
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20
5.2 Албан шаардлага.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ
Д.БАТЖАРГАЛ ТАНАА

2019.03.25 № 01/569
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч тус хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардал, гэрээ ажил үйлчилгээ, нягтлан бодох бүртгэл, харьяа байгууллагад өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 2019 оны 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж хариуцан гүйцэтгэв.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 05/1500 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан

үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Биологийн гаралтай зарим эд мөрийн баримт, дээжийг /ураг, эд эрхтэн/ хадгалах хөлдөөгчтэй болох.

Биологийн гаралтай зарим эд мөрийн баримт, дээж хадгалах зорилгоор Тусгай шинжилгээний газарт ашиглаж байсан хөлдөөгчийг Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэст шилжүүлж, хөлдөөгчтэй болсон. Тусгай шинжилгээний газрын ДНХ-ийн шинжилгээний лабораторид дээж хадгалах гүн хөлдөөгч худалдан авч суурилуулан ашиглаж байна.

- Шинжилгээний бүртгэл, мэдээлэл, лавлагааны улсын хэмжээний нэгдсэн систем бий болгох бэлтгэл ажлыг хангаж ажиллах.

БНСУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжих “Шинжилгээний бүртгэл мэдээлэл, лавлагааны улсын хэмжээний нэгдсэн систем” байгуулах ажлын хүрээнд БНСУ-ын Дотоод хэргийн яамны судалгааны баг 2016 оноос хойш 3 удаа ирж ажилласан байна.

- Дижитал судлалын шинжилгээний лаборатори байгуулах талаар судалгаа хийх.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Дижитал судлалын шинжилгээний лабораторид шаардлагатай “Дуу авианы шинжилгээний систем”-ийн программ хангамж, техник, тоног төхөөрөмжийг худалдан авсан байна. “КОЙКА” Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагын шугамаар буцалтгүй тусламжаар 2020 онд хэрэгжүүлэх төслийн саналыг БНСУ-ын Үндэсний шүүхийн шинжилгээний албатай хамтран боловсруулж 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр 01/4618 тоот албан бичгээр холбогдох байгууллагад уламжлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. Төслийн саналд тус хүрээлэнгийн шүүх дижитал шинжилгээний чадамжийг сайжруулах зорилгоор шинжээчдийг урт, богино

хугацааны сургалтад үе шаттайгаар хамруулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж, сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг тусгасан байна.

- Гэмт хэрэгтний сэтгэл зүйн шинжилгээний лабораторид шаардлагатай техник, тоног төхөөрөмж болон программыг судлах.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Медимпекс интернэйшнл” ХХК-наас “Сэтгэл зүйн шинжилгээний лаборатори”-ийн “Диана-07М ПК+программ хангамж”, техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхлээд байна.

- Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон аймгийн шүүхийн шинжилгээний албаны “Папилон” системийн Скайнеруудыг шинэчлэх.

“Адис-Папилон” системийн Скайнеруудыг “Киберком” ХХК-иас 28 ширхэг “Epson Perfection v800” маркийн скайнерийг хүлээн авч, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар болон аймгийн шүүхийн шинжилгээний албадуудын ажлын шаардлага хангахгүй болсон скайнеруудыг сольж, албаны шуурхай бэлэн байдлыг хангаж ажилласан байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Шүүхийн шинжилгээний тухай хууль
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дотоод аудитын алба 6 байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр дотоод хяналт шалгалт хийж нийт 1.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, тус зөрчлийг газар дээр нь арилгуулж хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувийг сонгов.

Энэ нь тус хүрээлэнгийн зарцуулах төсвийн 94.0 хувь буюу 10,881.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 6.0 хувь буюу 690.3 сая төгрөгийг Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагдсан учир зардлын гүйлгээ эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 10,911.3 сая төгрөгийн 2 хувь буюу 218.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2 хувиар тооцсон нь эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 23 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Үүнээс: Гэрээгээр хийлгэсэн	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	17	-	1	5	-
	Дүн	17	-	1	5	-

Аудитаар 17 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 5 санхүүгийн тайланд “итгэл үзүүлсэн”, 1 санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 138.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2.7 хувь буюу 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 19.3 хувь буюу 26.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 78 хувь буюу 107.7 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	31	26.2	6	3.7	4	5.0	21	17.5	-	-	-	-
2	ТТЗ /түүвэр/	6	111.9	-	-	1	21.7	5	90.2	-	-	-	-
	Дүн	37	138.1	6	3.7	5	26.7	27	107.7	-	-	-	-

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 17.5 сая төгрөгийн 21 зөвлөмж, 5.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3.7 сая төгрөгийн 6 акт тогтоосон байна.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцон шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Ажиллагсдын цалингаас байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 21.7 сая төгрөгийн суутгал суутгасан байна. Тухайлбал: Мобиком, Жи Мобойлд ажилтнуудын гар утасны төлбөрийг суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-д "Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгалыг /орлогын албан татварыг оролцуулахгүйгээр/ цалин хөлсний 20 хувиас, ... хэтрүүлж болохгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага тогтоов.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн бодолт, цагийн бүртгэл, газрын үнэлгээ болон дахин үнэлгээний талаар гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 5 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 11,572.0 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 10,881.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 690.3 сая төгрөгийг Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 690.3 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэл 720.7 сая төгрөг буюу 30.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийт төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд орлогын төлөвлөгөө давсан боловч зарим байгууллагын орлого тасарсан байна. Үүнд:

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	5,500,000.0	4,434,200.0	1,065,800.0	80.6
Дундговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба	5,000,000.0	4,463,000.0	537,000.0	89.3
Завхан аймгийн Шүүхийн шинжилгээний алба	6,500,000.0	4,938,800.0	1,561,200.0	76.0
Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний алба	5,500,000.0	5,450,103.0	49,897.00	99.1
Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба	4,000,000.0	2,804,500.0	1,195,500.0	70.1

Зардлын нийт гүйцэтгэл 11,506.7 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна. Энэ нь орон тоо дутуу ажиллах төсвийн хэмнэлтийн горимтой ажилласан, зайлшгүй

шаардлагтай эм урвалж бодис худалдан авах гэсэн боловч дотоодын зах зээлд байхгүй байсан зэрэг шалтгаалжээ.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн төсвөөр Шинжлэх ухаан технологийн сан, НҮБ болон ХЗДХЯ-ны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, Аймаг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс нэн шаардлагатай хөрөнгийг шийдүүлсэн байна. Үүнд: Нийслэлийн засаг даргаас хэн нь үл мэдэгдэх эзэнгүй цогцос оршуулах зардал нийт 134.6 сая төгрөг, НҮБ-аас нэг цэгийн үйлчилгээнд зориулж 20.0 сая төгрөг Шинжлэх ухаан технологийн сангаас гэмт хэрэгтний ДНК сан байгуулахад 97.7 сая төгрөг, бусад орон нутгийн Засаг даргаас 68.4 сая төгрөг нийт 350.0 сая төгрөгийг Сангийн сайдын зарцуулах эрхийн журмын дагуу эм урвалж, томилолт, байрны түрээс, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, урсгал засвар зэрэг зардлуудад зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 117 мэдээллээс хугацаандаа оруулсан 102 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 15 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шууд зардлаар бүртгэсэн 5.4 сая төгрөг, техник хяналтын актгүй автомашины засвар үйлчилгээнд 10.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолын хавсралт 9, 11-т заасныг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан, залилан үүсэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолын хавсралт 9, 11-т заасныг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус хүрээлэнгийн захирлын 2018 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалуудын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдөж байна. Дээрх тушаалуудаар нийт 17.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан, залилан үүсэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох хууль эрх зүйг мөрдөн ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Гэрээ ажил үйлчилгээтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нэр бүхий 2 байгууллагатай нийт 42.8 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч тус гэрээ дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдээгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль эрх зүй зөрчигдөх маргаан гарах.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид аливаа гэрээг дүгнэж акт, тэмдэглэл хөтөлж гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Зардалтай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Нийт 14.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд: Эм бэлдмэлийн зардлаас 2.1 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээс 0.4 сая төгрөг, урсгал засвараас 0.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 11.2 сая төгрөгөөр тус тус бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, ашиглан, залилан үүсэх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 42 дугаар зүйлийн 42.7-д заасныг мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5 Төсвийн шууд захирагчдад илэрсэн алдаа зөрчлийн талаар

3.5.1 Илрүүлэлт:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 17.5 сая төгрөгийн 21 зөвлөмж, 5.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3.7 сая төгрөгийн 6 акт тогтоосон байна.

3.5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам, дүрэм зөрчигдөх.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллах, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг хүргүүлэх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	260,650.0	603,696.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,234.5	68,863.1
АВЛАГА	2,072.8	3,244.5
БАРАА МАТЕРИАЛ	246,342.6	531,588.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,380,714.6	13,634,590.1
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,380,714.6	13,634,590.1
Биет хөрөнгө	4,376,729.2	12,818,135.6
Биет бус хөрөнгө	3,985.4	816,454.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,641,364.5	14,238,286.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР	160.5	358,125.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	160.5	358,125.0
Өглөг	160.5	358,125.0
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,641,204.0	13,880,161.5
Засгийн газрын хувь оролцоо	4,641,204.0	13,880,161.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,298,812.7	6,112,002.7
Хуримтлагдсан үр дүн	-862,482.8	2,738,847.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	204,874.1	5,029,311.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,641,364.5	14,238,286.5

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,003,692.7	15,407,962.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,028,753.1	4,108,906.3
Нийтлэг татварын бус орлого	1,028,753.1	4,108,906.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,974,939.6	11,299,055.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,422,187.8	10,911,304.6
УРСГАЛ ЗАРДАЛ	10,422,187.8	10,786,758.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,577,687.3	10,063,910.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,805,729.4	6,854,882.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	225,380.2	217,857.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,983.4	242,301.0
Хангамж, бараа материалын зардал	307,116.7	446,233.2
Нормативт зардал	1,030,806.2	993,870.9
Эд хогшил, урсгал засварын зардал	87,516.4	189,995.8
Томилолт, зочны зардал	81,201.3	125,392.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,175.8	145,650.0
Бараа үйлчилгээний бусад зардал	721,777.9	847,726.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	844,500.5	722,848.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	124,545.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	581,504.9	4,496,657.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,960.9	1,091,690.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	429,544.0	3,404,967.0

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,359,202.4	12,028,131.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	384,262.8	815,314.8
Нийтлэг татварын бус орлого	384,262.8	815,314.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,974,939.6	11,212,816.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,860,547.1	10,086,665.1
УРСГАЛ ЗАРДАЛ	9,860,547.1	10,086,665.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,003,274.7	9,684,927.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,788,572.0	6,850,491.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,443.2	221,031.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,468.0	244,218.4
Хангамж, бараа материалын зардал	323,039.2	418,307.6
Нормативт зардал	1,049,762.6	1,277,394.9
Эд хогшил, урсгал засварын зардал	112,350.1	205,074.0
Томилолт, зочны зардал	83,412.2	125,854.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,703.1	153,479.2
Бараа үйлчилгээний бусад зардал	94,524.4	189,075.0
ХҮҮ	0.0	0.0
ТАТААС	0.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	857,272.4	401,737.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	498,655.3	1,941,466.4
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	488,146.3	1,884,837.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	488,146.3	1,884,837.8
Дотоод эх үүсвэрээр	488,146.3	1,884,837.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-488,146.3	-1,884,837.8
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,509.0	56,628.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,725.5	12,234.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,234.5	68,863.1

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,207,598.5	-	4,207,598.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,061.5	-	4,061.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,211,660.0	-	4,211,660.0
Тайлант үеийн үр дүн	429,544.0	-	429,544.0
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,641,204.0	-	4,641,204.0
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,641,204.0	-	4,641,204.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	196,363.5	-	196,363.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,837,567.6	-	4,837,567.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	5,637,627.0	-	5,637,627.0
Тайлант үеийн үр дүн	3,404,967.0	-	3,404,967.0
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,880,161.5	-	13,880,161.5

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,572,044.4	11,506,675.2	65,369.2	99.4
УРСГАЛ ЗАРДАЛ	10,032,144.4	9,986,129.7	46,014.7	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,717,985.1	9,672,193.5	45,791.6	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,834,655.5	6,830,491.6	4,163.9	99.9
Үндсэн цалин	3,751,418.5	3,744,064.8	7,353.7	99.8
Нэмэгдэл	2,377,336.0	2,380,208.2	-2,872.2	100.1
Унаа хоолны хөнгөлөлт	705,901.0	706,218.7	-317.7	100.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	248,976.4	220,793.9	28,182.5	88.7
Тэтгэврийн даатгал	102,673.5	95,204.5	7,469.0	92.7
Тэтгэмжийн даатгал	9,620.5	7,762.2	1,858.3	80.7
ҮОМШӨ-ний даатгал	11,995.7	9,074.1	2,921.6	75.6
Ажилгүйдлийн даатгал	2,404.6	1,807.5	597.1	75.2
Эрүүл мэндийн даатгал	122,282.1	106,945.6	15,336.5	87.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245,167.7	240,468.4	4,699.3	98.1
Гэрэл, цахилгаан	61,464.2	60,694.3	769.9	98.8
Түлш, халаалт	137,207.8	136,116.5	1,091.3	99.2
Цэвэр, бохир ус	32,961.7	30,627.5	2,334.2	92.9
Байрны түрээс	13,534.0	13,030.1	503.9	96.3
Хангамж, бараа материалын зардал	419,443.9	418,927.8	516.1	99.9
Бичиг хэрэг	58,261.3	58,994.0	-732.7	101.3
Тээвэр, шатахуун	217,174.1	216,028.8	1,145.3	99.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,417.9	46,875.0	542.9	98.9
Ном, хэвлэл	7,200.0	7,199.3	0.7	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,932.1	25,693.4	238.7	99.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,458.5	64,137.4	-678.9	101.1
Нормативт зардал	1,210,210.0	1,206,205.5	4,004.5	99.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	631,688.7	627,089.3	4,599.4	99.3
Хоол, хүнс	66,608.3	67,204.2	-595.9	100.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	511,913.0	511,912.0	1.0	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	484,899.7	484,171.8	727.9	99.9
Багаж, техник, хэрэгсэл	320,348.3	320,574.2	-225.9	100.1
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,852.8	39,421.7	1,431.1	96.5
Урсгал засвар	123,698.6	124,175.9	-477.3	100.4
Томилолт, зочны зардал	121,496.7	120,554.9	941.9	99.2
Дотоод албан томилолт	121,496.7	120,554.9	941.9	99.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,907.8	135,352.2	2,555.6	98.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	99,260.3	97,530.2	1,730.1	98.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,860.0	2,860.0	-	100.0
Даатгалын үйлчилгээ	6,108.3	5,926.2	182.1	97.0
Тээврийн хэрэгслийн татвар	3,331.4	2,828.0	503.4	84.9
Тээврийн хэрэгслийн оношлогоо	923.5	783.5	140.0	84.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,000.0	13,000.0	-	100.0
Газрын төлбөр	207.6	207.6	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	12,216.7	12,216.7	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	15,227.4	15,227.4	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,227.4	15,227.4	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	314,159.3	313,936.2	223.1	99.9

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад урсгал шилжүүлэг	314,159.3	313,936.2	223.1	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	28,080.0	27,856.9	223.1	99.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,634.8	47,634.8	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	213,444.5	213,444.5	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,000.0	25,000.0	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,539,900.0	1,520,545.5	19,354.5	98.7
Барилга байгууламж	590,000.0	589,903.1	96.9	100.0
Их засвар	90,400.0	89,243.5	1,156.5	98.7
Тоног төхөөрөмж	859,500.0	841,398.9	18,101.1	97.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,572,044.4	11,506,675.2	65,369.2	99.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,881,715.8	10,785,984.6	95,731.2	99.1
Улсын төсвөөс санхүүжих	10,881,715.8	10,785,984.6	95,731.2	99.1
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	690,328.6	720,690.6	- 30,362.0	104.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	690,328.6	720,690.6	- 30,362.0	104.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,234.5	-12,234.5	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	68,863.1	-68,863.1	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1.1	1.1	0	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	0	100.0
Төсвийн байгууллага	23	23	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	514	514	0	100.0
Удирдах ажилтан	34	34	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	448	448	0	100.0
Үйлчлэх ажилтан	32	32	0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	514	514	0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0	0	0	0.0
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	498	502	-4	100.8
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	0	100.0

5. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2018 он		Аудитын нэр: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит		Аудитын код: САГ-2019/10/СТА-ТТЗ					
Шалгагдсан байгууллагын		Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн				сая төгрөгөөр			
№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Зардал		Шууд зардлаар бүртгэсэн 5.4 сая төгрөг, техник хяналтын актгүй автомашины засвар үйлчилгээнд 10.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.	15.8	Зөвлөмж өгсөн			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий нягтлан бодогч	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат
2	Зардал	2	Тус хүрээлэнгийн захирлын 2018 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалуудын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдөж байна. Дээрх тушаалуудаар нийт 17.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	17.5	Зөвлөмж өгсөн			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий нягтлан бодогч	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат
3	Гэрээ ажил үйлчилгээ	3	Нэр бүхий 2 байгууллагатай нийт 42.8 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч тус гэрээг дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдээгүй байна.	42.8	Зөвлөмж өгсөн			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат
4	Үндсэн хөрөнгө	1	Нийт 14.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд: Эм бэлдмэлийн зардлаас 2.1 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээс 0.4 сая төгрөг, урсгал засвараас 0.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 11.2 сая төгрөгөөр тус тус бэлтгэсэн байна.	14.1	Зөвлөмж өгсөн			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий нягтлан бодогч	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат
5	Харьяа байгууллага	1	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 17.5 сая төгрөгийн 21 зөвлөмж, 5.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3.7 сая төгрөгийн 6 акт тогтоосон байна.	26.2	Зөвлөмж өгсөн			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий нягтлан бодогч	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат
6	Цалин /суутгал/	1	Ажиллагсдын цалингаас байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 21.7 сая төгрөгийн суутгал суутгасан байна. Тухайлбал: Мобиком, Жи Мобойлд ажилтнуудын гар утасны төлбөрийг суутгасан байна.	21.7	Албан шаардлага			1. Санхүү төлөвлөлт, хангамжийн газрын дарга, цагдаагийн хурандаа 2. Ерөнхий нягтлан бодогч	1. О.Шагдарсүрэн 2. Г.Оюунбат



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 03 дугаар сарын 25 № 02/127 Улаанбаатар хот
 С.ЯТ- 2019/10/СТА-773
 Зөрчил арилгах тухай





Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажиллагсдын цалингаас байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 21.7 сая төгрөгийн суутгал суутгасан байна. Тухайлбал: Мобиком, Жи Мобайлд ажилтнуудын гар утасны төлбөрийг суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2-д "Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгалыг /орлогын албан татварыг оролцуулахгүйгээр/ цалин хөлсний 20 хувиас, ... хэтрүүлж болохгүй" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажиллагсдын цалингаас байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй суутгалыг дараа дахин гаргахгүй байх.
2. Биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Санхүү, төлөвлөлт, хангамжийн газрын дарга цагдаагийн хурандаа О.Шагдарсүрэн нарт хариуцуулав.

<p>ТОГТООСОН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ АУДИТОР  Д.ЦЭГМИДДОРЖ</p>	<p>АЛБАН ШААРДЛАГА</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН: ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ, БРИГАДЫН ГЕНЕРАЛ  Д.БАТЖАРГАЛ САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАМЖИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  О.ШАГДАРСҮРЭН</p>
---	-------------------------------	--

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, spanning the width of the page.